

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР 151021-6
ХАВСРАЛТ 1
ОГНОО 2023 оны 02-р сарын 16-ны өдөр

УТГА Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн борлуулалтын орлогын сарын мөчлөгтэй холбоотойгоор Компанид шаардлагатай байгаа ажлын капиталын санхүүжилтийн хэрэгцээг нөхөх зорилгоор Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Премиум Групп ХХК-иас богино хугацааны зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг авч хэлэлцээд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дох заалт, 91 дүгээр зүйлийн 91.2 дох заалт, Компанийн Дүрмийн 9.4.18 дах заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийг жилийн 18 (арван найман) хувийн хүүтэй 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгийн богино хугацааны зээлийг Премиум Групп ХХК-иас авахыг зөвшөөрч, Премиум Групп ХХК-тай байгуулах Зээлийн гэрээг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Премиум Групп ХХК-тай байгуулах Зээлийн гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг) болон Санхүүгийн газрын захирал (С.Дашдорж)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолд Компанийн тухай хуулийн дээр дурдсан холбогдох заалтуудыг үндэслэн сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүд санал өгөхөөс түтгэлзсэн болохыг дурдсугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ДУГААР 151021-6
огноо 2023 оны 02-р сарын 16-ны өдөр



		ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТҮДГЭЛЗСЭН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ			x 
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД			x 
	О.БАТМӨНХ			x 
	Г.БАТ-ЭРДЭНЭ			x
	Г.ЧИНЗОРИГ	x		
	Б.БАТ-ЭРДЭНЭ	x		
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н.ЭНХБОЛД	x		
	В.ГАНЗОРИГ			
	ГАРИ СТИВЕН БИОНДО	x		
ТОГТООЛЫН БАТЛАГДСАН ХУВЬ:		100%		